

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 1

Рашаант

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тухай

“Талын гал” ХК-ийн 2017 оны үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга У.Батсуурийн илтгэлийг хэлэлцээд тэмдэглэх нь:

Тус компанийн гүйцэтгэх удирдлага, Төлөөлөн Удирдах Зөвлөл 2017 онд үйлдвэрлэлийн төлөвлөгөөт үзүүлэлтийг биелүүлэх, жигд ажиллагааг хангах, ажлын зохион байгуулалтыг дээшлүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын үр дүнтэй арга хэмжээ авч хэрэглэгчдийг нүүрсээр хангах үндсэн үүргээ амжилттай биелүүлснийг сайшаан тэмдэглэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Талын гал” ХК-ийн 2017 оны үйл ажиллагаанд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг зөвшөөрсүгэй. Тайлангийн хугацаанд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын дүнг хангалттай гэж үзсүгэй.

Хоёр. Доорхи зорилтыг 2018 онд дэвшүүлэн ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг нэр төрлөөр нь чанар өндөр үзүүлэлтээр ханган биелүүлэх.
2. Тоног төхөөрөмж, машин техникийн засварын ажлын чанарыг сайжруулах замаар гэнэтийн эвдрэл саатал, сул зогсолтыг эрс багасгаж төлөвлөгөөт бус засварын ажлын болон сэлбэгийн зардлыг багасгах, зардал хямдруулах арга хэмжээ авах.

Гурав. Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарсан санал шүүмжлэлийн мөрөөр цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ажиллахыг гүйцэтгэх захирал /С.Цэрэндондов/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Тогтоолын биелэлтийг хангуулах талаар гүйцэтгэх удирдлагад дэмжлэг туслалцаа үзүүлж түүний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл /У.Батсуурь/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА:



У.БАТСУУРЬ

С.ЦЭРЭНДОНДОВ

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 2

Рашаант

Хянан шалгагчийн тайлан,
дүгнэлтийн тухай

“Талын гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Талын гал” ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд Хянан шалгагчаас хийсэн дүгнэлт, Хянан шалгагчийн 2017 онд хийсэн ажлын тайланг зөвшөөрсүгэй.
2. Хяналт шалгалтын ажлын үр нөлөөг дээшлүүлж, компанийн санхүүгийн чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Хянан шалгагч /Ш.Мягмарсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



У.БАТСУУРЬ

С.ЦЭРЭНДОНДОВ

**“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 3

Рашаант

Төсөв батлах тухай

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг 12 /арван хоёр/ сая төгрөгөөр, Хянан шалгагчийн төсвийг 3 /гурван/ сая төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл /У.Батсуурь/ болон Хянан шалгагч /Ш.Мягмарсүрэн/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



У.БАТСУУРЬ

С.ЦЭРЭНДОНДОВ

**“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 4

Рашаант

Ногдол ашиг хуваарилах тухай.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг авч хэлэлцээд тус компанийн хувьцаа эзэмшигчдэд нэг хувьцаа тутамд 50 /тавин/ төгрөгийн ногдол ашиг хуваарилах нь зүйтэй гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



У.БАТСУУРЬ

С.ЦЭРЭНДОНДОВ